



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 02 дугаар сарын 09 өдөр

Дугаар 05

Хэрлэн сум

V ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 05 дугаар хуралдаан 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 85,7 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Малын гоц халдварт өвчний нөхцөл байдлын талаарх мэдээлэл танилцуулах,

*Мал эмнэлгийн газар*

2.Аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл танилцуулах,-

*Хүнс, хөдөө аж ахуйн газар*

3.Улсын онцгой комиссын 2023 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврыг танилцуулах,

*Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

4.УОК-ын 2023 оны 01 дүгээр албан даалгавартай холбогдуулан аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл танилцуулах,

*Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Аюушмаа-д:

1.1.Малын гоц халдварт өвчний нөхцөл байдлын мэдээллийг дээд шатны байгууллагын батлагдсан маягтын дагуу гаргаж боловсруулах,

1.2.Сумдын Мал эмнэлгийн байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор малын халдварт өвчнүүдийн үед мөрдөх хорио цээрийн дэглэм сахиулах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай захирамжийн төсөл боловсруулж аймгийн Засаг даргын захирамжаар батлуулах,

10  
/  / М.Бадамсүрэн  
/ х/ч Б.Цогтбаяр

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.3.Малын гоц халдварт өвчний тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан Хээлтүүлэгч малын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл боловсруулж батлуулах,

Хоёр.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ш.Ёл,

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,  
Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбаяр,  
Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга Г.Гарамхишиг нарт:

2.1.Сумдын нөөцийн өвсийг өвөлжилт хүндэрч болзошгүй сумдын малчдад хөнгөлттэй үнээр хуваарилан олгох талаар мэргэжлийн байгууллагуудын бүрэлдэхүүнтэй хуралдаж шийдвэрлэх,

Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбаяр-т:

2.2.Аймгийн аюулгүйн нөөцийн санд хадгалагдаж буй өвс, тэжээлийг цагаан зуд, цагаанаар зудархуу ангилалд байгаа сумд болон Хэрлэн сумын зөвшөөрсөн бүсийн мал маллаж буй малчин өрхүүдэд Мал хамгаалах сангийн зохих журмын дагуу хуваарилан олгох,

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,

2.3.Сумдын өвсний нөөцийн хамгаалах зорилгоор хяналтын камерыг сум тус бүрт 1 ширхэгийг шийдвэрлэж олгох зардлыг тооцох, аймгийн Мал хамгаалах сангаас хөрөнгийг шийдвэрлэх,

Гурав. Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Улсын онцгой комиссын 2023 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгавар гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" албан даалгавар, Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА  М.БАДАМСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ХОШУУЧ  Б.ЦОГТБАЯР